

# ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 7 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн орон даяар цахимаар санал, асуулга хэлбэрээр зохион байгуулж, төсвийн тодотголын төсөлтэй холбоотой иргэдийн санал, хүсэлт, асуултыг нээлттэй утас, цахим шуудан болон шуудангаар хүлээн авч ажиллалаа.

Төсвийн тодотголын төслийн талаар олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл хүргэх, иргэдийн оролцоог хангах, төсвийн бодлого, төсвийн зарцуулалтын талаар иргэд, олон нийтийн байр суурь, санал хүсэлтийг сонсох зорилгоор 2026 оны 8 дугаар сарын 07-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох албан тушаалтнууд болон бусад оролцогч нийт 125 хүн оролцож, төсвийн тодотголын төслийн талаарх мэдээлэлтэй танилцан, санал, дүгнэлт гаргаж, асуулт асууж, хариулт авлаа.

Нийт ирүүлсэн санал, хүсэлт, асуулгыг агуулгын хувьд нэгтгэн үзэхэд төсвийн зардлыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, шаардлагагүй болон давхардсан зардлыг бууруулах, нэн тэргүүний хэрэгцээтэй салбар, арга хэмжээнд төсвийн хөрөнгийг эрэмбэлэн чиглүүлэх, хүнс болон шатахууны үнийн өсөлтөөс иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх дарамтыг бууруулах, 2026-2027 оны өвөлжилтийн эрчим хүчний найдвартай байдлыг хангах, нийтийн тээврийн хүртээмж, чанарыг сайжруулах, төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн зардлын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулах чиглэлийн санал, хүсэлтүүд давамгайлж байна.

Мөн олон нийтийн зүгээс төсвийн тодотголыг зөвхөн төсвийн орлого, зарлагын тоон өөрчлөлтөөр хязгаарлахгүйгээр эдийн засаг, нийгмийн цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэх, төсвийн хязгаарлагдмал нөөцийг иргэд, эдийн засагт хамгийн өндөр үр өгөөжтэй арга хэмжээнд эрэмбэлэн зарцуулах шаардлагатай талаар санал гаргасан.

# ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Эдийн засаг, хөгжлийн яамны хурлын танхимд  
2026.08.07-ны өдөр 14:00-17:30 цагт



## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

28<sup>1.2</sup>. Олон нийтийн хэлэлцүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 8 дугаар сард, **төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн** хугацаанд зохион байгуулна.

✓ Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг **танхимаар** зохион байгуулж иргэд, олон нийтээс холбогдох саналыг **утсаар болон цахим** хэлбэрээр авч ажиллалаа.

Оролцогчдын тоо: 125

Оролцогчид:

- Сангийн яам
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Боловсролын яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам
- Үндэсний статистикийн хороо
- Санхүүгийн зохицуулах хороо
- Үндэсний аудитын газар
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл
- Монголын ББСБ-уудын Холбоо
- Судлаачид /СЭЗИС, МУИС/
- Иргэд